



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/23

Алтрага

**Хүлээж авах хяналт тавих  
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Тэжээлийн нөөц бүрдүүлэх” ажлыг хүлээж авах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Баттулга  
(Тамгын газрын даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)

Гишүүн: Н.Лхагвадулам  
(МАА-н үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, үржил  
бүртгэл, бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Баярхүү  
(Тамгын газрын нярав)

2.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Тэжээлийн нөөц бүрдүүлэх” ажлыг хууль журмын хүрээнд хүлээж авахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

**6729010054**